



БОГД БАНКНЫ ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН Д.МОЛОМЖАМЦЫН 2022 ОНЫ НЭГДУГЭЭР УЛИРАЛД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Богд банк Монгол улсын зах зээл дээр багагүй үүрэг гүйцэтгэн улсын эдийн засагт хөрөнгө оруулалт хийж, харилцагчийн шаардлагыг хангасан банкны үйлчилгээ үзүүлж байна. Монголын эдийн засагт, түүний дотор бизнесийн үйл ажиллагаанд цар тахалын болон Украины дайны сөрөг үр дагавар ихээхэн нөлөөлж байгаа хэдий ч Банкны удирдлагын зүгээс энэ хүнд нөхцөлд банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах тусгай төлөвлөгөө гарган ажилласны үр дүнд Банкны уйл ажиллагаа энэ оны эхний улиралд нэг их доголдолгүй явж ирсэн гэж хэлж болно. Мэдээж цар тахалын болон Украины дайны улмаас банкны уйл ажиллагааг тэлэх талаар төлөвлөсөн зорилтуудыг бүрэн хэрэгжүүлэх боломж гараагүй нь ойлгомжтой Богд банк 2022 оны 3 сарын 31-ний байдлаар 12 салбар нэгжтэй ажиллаж, тэдгээрт 200 орчим хүн хөдөлмөрлөж байна. Харилцагчдын тоо ч нэмэгдэж байна. Богд банк 50 гаруй мянга гаруй харилцагчтай байна.

Богд банк нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны гол үзүүлэлтийг ханган ажиллаж байна. Богд банк нь банкны салбарын анхдагч нээлттэй хувьцаат компанийн статус бүхий арилжааны банк болох зорилгоо амжилтай хэрэгжүүлж, 12,500,000 ширхэг үнэт цаас гарган борлуулж чадсан байна. Үүний үр дүнд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 100 000 000 000,00 төгрөг болж, оны эхнээс хоёр дахин нэмэгдэж, энэ талаар Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг биелүүлж байна. Банкны актив хөрөнгө 2022 оны 3 сарын 31-ны байдлаар 369 243 490 982,94 тегрег болж, оны эхнээс 42191271141.1 тегрегеер буюу 12,9 хувиар өссөн байна. Банкны нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 103 022 468 140,77 төгрөг байгаа нь энэ оны эхнээс 1,4 хувиар өсчээ.

МОНГОЛ БАНКНААС ТОГТООСОН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	Байвал зохих	Биелэлт
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	>9%	41,5%
Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	>12%	41,5%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	>25%	45,3%
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	<±15%	4,0%
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)	<±30%	5,1%



Монголбанкнаас тогтоосон шалгуур гол үзүүлэлтүүд, тухайлбал, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн активын харьцаа, өөрийн хөрөнгө ба эрсдэлээр жигнэсэн активын харьцаа нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байна. Гадаад валютын нээлтэй позици дээр анхаарах шаардлагатай. Банкны зээлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, зээлийн чанар өнгөрсөн оноос муудаагүй байна. Хугацаа хэтэрсэн зээ 6 683 931 756,91 тегрег байгаа нь оны эхнээс (6 559 966 539,53 тегрег) бага зэрэг есех хандлагатай байгааг анхаарах шаардлагатай.

2022 оны нэгдүгээр улиралд ТУЗ 31 удаа хуралдсан болно. Бүх хурал зайнаас оролцож хараат бус гишүүний хувьд өөрийн байр суурийг илэрхийлж байсан болно. Мөн Аудитын хороо 1 удаа, Урамшуулалын хороо 1 удаа хуралдсан байна. Эдгээр хурлуудаар банкны үйл ажиллагааны олон талт асуудлыг зохих журмын дагуу хэлэлцэж, зохих шийдвэрийг гаргаж ирсэн байна. Аудитын хорооны болон Эрсдлийн удирдлагын хорооны хуралд тогтмол оролцож, хэлэлцэж буй асуудлаар өөрийн саналыг хурлын шийдвэрт тусгуулж байна. Компанийн тухай хуульд заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож санал өгч ажилласан болно. Мөн Банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн, хууль тогтоомжийг зөрчсөн шийдвэрийг ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын зүгээс гаргаагүй болно. Хараат бус гишүүний чиг үүргийн дагуу эрсдэлийн болон санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр холбогдох нэгжүүдтэй ойрхон ажиллаж, энэ чиглэлээр ТУЗ болон Банкны удирдлагад зөвлөмж өгч ажиллаж байна. Монголын эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн тогтвортой бус байдлаас улбаалж, цаашид банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох эрсдлийг тогтоож, сэрэмжлэх арга хэмжээ авахад Банкны удирдлагад туслахад ТУЗ-ийн хараат бус гишүүний үүргийн хүрээнд анхаарч байна.

БОГД Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн
2022.04.08

Д.Моломжамц